



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР**



ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР
СУРГАЛТ СУДАЛГАА МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

СҮМ ХИЙДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМРАГДДАГ БОЛОН ШАВИЛАН СУУЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА

Улаанбаатар хот
2019

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт.....	3
Графикийн жагсаалт.....	3
Товчилсон үгс.....	4
Нэр томъёоны тайлбар.....	5
БҮЛЭГ НЭГ. УДИРТГАЛ.....	6
1.1 Судалгааны үндэслэл.....	6
1.2 Судалгааны зорилго, зорилт.....	7
БҮЛЭГ ХОЁР. АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....	8
2.1 Судалгааны хамрах хүрээ.....	8
2.2 Судалгааны аргууд.....	8
2.3 Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт.....	8
БҮЛЭГ ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ШАШНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН.....	9
3.1 Олон улсын гэрээ болон дотоодын хууль эрх зүйн байдал.....	9
3.2 Шашны байгууллага, түүний бүртгэл.....	10
БҮЛЭГ ДӨРӨВ. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН.....	14
4.1 Сүм хийдүүдээс авсан асуулга судалгааны үр дүн.....	14
4.1.1 Сүм хийдийн ерөнхий мэдээлэл.....	14
4.1.2 Сүм хийдийн үйл ажиллагаанд хамрагддаг хүүхдүүдийн нөхцөл байдал.....	15
4.1.3 Сүм хийдээс хүүхдэд үзүүлж буй үйлчилгээ, хамгааллын асуудлууд.....	19
4.2 Шавилсан болон өдрөөр ирж үйлчилгээнд хамрагддаг хүүхдүүдээс авсан ганцаарчилсан ярилцлагын үр дүн.....	22
4.2.1 Судалгаанд хамрагдагсдын ерөнхий шинж.....	22
4.2.2 Хүүхдүүдийн сүм хийдийн үйл ажиллагаанд татагдаж буй шалтгаан.....	22
4.2.3 Сүм хийдийн хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаанд хамрагддаг хүүхдүүдийн эрх, хамгааллын байдал.....	23
4.2.4 Сүм хийдээс үзүүлж буй үйл ажиллагааны талаарх хүүхдүүдийн сэтгэл ханамжийн байдлыг үнэлэх.....	28
ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	31

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 3.1. Үндэсний статистикийн хорооны нэгдсэн санд байршуулсан тоо баримт , (2019 он):

Хүснэгт 4.1. Шавилан суусан хүүхдийн эрхийн зарим нөхцөл байдал, хувиар

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Зураг 4.1. Үйл ажиллагаандаа хүүхэд хамруулдаг сүм хийдүүдийн газар зүйн байршил, тоогоор 2019 он (N=127)

Зураг 4.2. Үйл ажиллагаанд нь хүүхэд хамрагддаг сүм хийдүүдийн шашны урсгалын төрлөөр, хувиар

Зураг 4.3. Сүм хийдийн үйл ажиллагаанд хамрагддаг хүүхдүүдийн насны бүлэг, хувиар, 2019 он (N=2750)

Зураг 4.4. Сүм хийдийн үйл ажиллагаанд хамрагддаг хүүхдүүдийн хүйсийн харьцаа, хувиар

Зураг 4.5. Сүм хийдийн үйл ажиллагаанд хамрагдсан хугацаа, хувиар, 2019 он (N=2750)

Зураг 4.6. Сүм хийдийн үйл ажиллагаанд хамрагддаг хүүхдийн ар гэрийн байдал, хувиар, 2019 он (N=2750)

Зураг 4.8. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сүм хийдэд хамрагдалтын хэлбэрээр, хувиар, 2019 он (N=16)

Зураг 4.9. Үйл ажиллагаанд өдрөөр ирж хамрагддаг хүүхдүүдийн давтамж, хувиар

Зураг 4.10. Шашны ном, библи сурахаас гадна бусад үйл ажиллагаанд хамрагдах байдал

Зураг 4.11. Ямар нэг сургалтын төлбөр, хоолны мөнгө зэрэг нэмэлт зүйл хүүхдүүдээс шаарддаг талаар

Зураг 4.12. Хүүхдүүдэд ямар нэг хэлбэрээр урамшуулал өгдөг эсэх

Зураг 4.13. Сүм хийдэд сахилга шийтгэл болон бие биенийгээ ялгаварлан гадуурхах насны ялгаа байдаг эсэх

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам
БтХ	Боловсролын тухай хууль
ГБХЗХГ	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НТБТ	Насан туршийн боловсролын төв
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
ХЭТХ	Хүүхдийн эрхийн тухай хууль
ТББ	Төрийн бус байгууллага
ТСХХтХ	Төр сүм хийдийн харилцааны тухай хууль

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Хүүхэд хамгаалал Нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагааг¹

Сүм хийд “Сүсэгтэн олны шашин-номын эрэлт хэрэгцээг хангах зорилгоор байгуулагдаж, шашны зан үйл, хурал ном, боловсролын ажлыг эрхлэн гүйцэтгэж буй албан ёсны зөвшөөрөл бүхий хийд, сүм, дацан, төв болон тэдгээрийн удирдах байгууллагыг шашны байгууллага гэнэ” хэмээн зааж, тэдгээрийг уг хуульд сүм хийд гэж нэрлэхээр заажээ.²

Буддын шашин (Buddhism) Буддын шашин зовлон, дахин төрөл авах орчлоос ангижирч нирваанд хүрэхийг эрхэмлэдэг. Үүний тулд бясалгал хийж, ёс суртахууны зарчим баримталдаг.³

Христийн шашин (Christianity) Есүсийн сургаалд үндэслэн МЭ I зуунд үүссэн шашин. Ариун судар нь Библи, тэр дундаа Шинэ гэрээ. Энэ шашин Есүс бол Бурханы хүү (Ариун гурвалын хоёр дахь бодгал), Бурханы хайр бүтээсэн ертөнцийнхөө оршин байх үндэс болдог, хүн төрөлхтний нүглийг цайруулахын төлөө Есүс үхсэн гэдэг үндсэн номлолтой. Санваартнууд нийтээрээ мөргөл үйлддэг, зарим сүмд тэднийг сүсэгтэн болон тэнгэрийн хоорондох зуучлагч гэж үздэг.

Исламын шашин Манай он тооллын VII зууны эхэнд Арабын хагас хойг арлын баруун хэсэгт (одоогийн Саудын Араб улсын нутаг дэвсгэрийн баруун хэсэгт) тухайн үеийн араб угсаатны нэгэн том овог болох курейшит овгийн дотор үүсчээ. Исламын ертөнцөд энэ шашны анх үүссэн цаг хугацааг албан ёсоор 622 он гэж үздэг. Энэ шашин нь 7-р зууны Арабын Элч Мухаммедэд илгээгдсэн шашин юм. Энэхүү шашинг шүтэгч хүнийг Мусульман гэдэг. Исламын шашинд ертөнцөд цорын ганц бурхан нь л байдаг гэж үздэг ба тэр нь Аллах. Гол судар нь Куран.

Сүм хийдэд шавилан суудаг хүүхдүүд нь сүм хийдийн дотуур байр, лам багшийн дэргэд шавилан сууж, шашны сургууль төгстлөө тэндээ амьдарч амралтаараа ар гэртээ харьдаг.

Сүмд өдрөөр ирж үйлчлүүлдэг хүүхдүүд нь өдөрт христийн сүмд ирж номлол сургааль сонсон, сүм, чуулганы үйл ажиллагаануудад хамрагддаг хүүхдүүдийг хэлнэ.

¹ Хүүхэд хамгааллын тухай хууль, 2-р зүйл, 2.1 дэх заалт

² Төр сүм хийдийн харилцааны тухай хуулийн 6-р зүйл

³ Britannica ширээний нэвтэрхий толь, 1531 дэх тал

БҮЛЭГ 1. УДИРТГАЛ

1.1. Судалгааны үндэслэл

Монгол Улсын Үндсэн хууль, Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал зэрэг бодлогын баримт бичигт иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг баталгаажуулж, төр ба шашны харилцааг хуульчилсан билээ.

1993 онд Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль батлагдсанаас хойш 25 жилийн хугацаанд нийт 5 удаа (1995, 1997, 2014 онд тус бүр 1 удаа, 2015 онд 2 удаа) нэмэлт, өөрчлөлт орсон.

Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль зохих хэмжээнд хэрэгжиж байгаа хэдий ч сүм хийд, цуглаан зэрэг шашны байгууллагын тоо эрс нэмэгдэж 1993 онд улсын хэмжээнд 93⁴ сүм, хийд үйл ажиллагаа явуулж байсан бол 2004 онд 225 болж⁵ 2.5 дахин нэмэгдсэн, 2018 онд 364 болж⁶, 13 жилийн дотор 139 сүм хийд шинээр байгуулагджээ. Үүнтэй холбоотойгоор шашны олон урсгал бүхий сүм, хийд олноор бий болж, сүм хийдэд хандах хүүхдийн тоо ч өсөх хандлагатай байна.

ХЗДХЯ-наас хийсэн шалгалтын мэдээгээр 2016 онд улсын хэмжээнд 6 төрлийн шашны 20 гаруй урсгалын 848 хуулийн этгээд шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нь тогтоогдсон⁷ бөгөөд эдгээр шашны байгууллагын 41.5 хувь буюу 352 байгууллага зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан байна.⁸

Энэ нь шашны байгууллагыг тодорхойлж буй хуулийн зохицуулалт оновчтой бус, сүм хийдийн салбар, төлөөлөгчийн газрууд нь тусгай зөвшөөрөлтэй байх эсэх асуудлыг тодорхой хуульчлаагүйтэй холбоотой байна.

Ийнхүү хяналт, бүртгэлийн сул талыг ашиглан шашны үйл ажиллагааг төрийн бус байгууллага (ТББ), боловсролын, эрүүл мэндийн болон хэвлэл мэдээллийн байгууллага төдийгүй ашгийн төлөөх хуулийн этгээдийн хэлбэрээр бүртгэгдсэн байгууллагууд ч эрхлэн явуулж байгаа тохиолдол цөөнгүй байна.⁹ Тухайлбал, 2017 оны байдлаар шашны чиглэлээр

⁴ “Гадаадын болон олон улсын шашны төрийн бус байгууллагуудын Монгол дахь үйл ажиллагаа, үр нөлөө” судалгаа. Хууль сахиулахын их сургууль. 2017 он.

⁵ Нийслэлийн сүм хийд, шашны байгууллагын 2014 оны толлогын тайлан.

⁶ Үндэсний статистикийн хорооны мэдээлэл. /www.nso.mn/-2019 он.

⁷ ХЗДХЯ-наас 2016 онд явуулсан шалгалтын тайлан

⁸ ХЗДХ-ийн сайдын 2016 оны А/73 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн шалгалтын дүн

⁹ ХЗДХ-ийн сайдын 2016 оны А/73 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн шалгалтын дүнд хавсаргасан шалгалт хийх шаардлагатай шашны үйл ажиллагаа явуулдаг байгууллагын жагсаалтанд

үйл ажиллагаа явуулдаг 40 гаруй олон улсын ТББ байна¹⁰ гэсэн судалгааны дүн байгаа боловч өөр зорилго, үйл ажиллагааны хэлбэрээр халхавчлан шашны үйл ажиллагаа эрхэлж байгаа хэчнээн ТББ байгааг тодорхойлох боломжгүй юм.

Түүнчлэн Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр¹¹ "... хуулийн хэрэгжилт хангалтгүй, хуулийн зохицуулалтын хийдлээс шалтгаалан шашны үйл ажиллагааг зөвшөөрөлгүй эрхлэх, ТББ болон хуулийн этгээдийн бусад хэлбэрээр халхавчлан хяналтгүйгээр шашны үйл ажиллагаа явуулах, сүсэг бишрэлээр нь далимдуулан иргэдийг сэтгэл санаа, эд хөрөнгөөр хохироох, насанд хүрээгүй хүүхдийг шашны үйл ажиллагаанд олноор нь татан оролцуулах зэрэг хууль зөрчсөн олон асуудал байна." хэмээн дүгнэсэн байна.

Иймд дээр дурдсан нөхцөл байдлыг харгалзан, өнөөгийн сүм хийдийн үйл ажиллагаанд хамрагдаж буй насанд хүрээгүй хүүхдүүдийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, захиалгыг ГБХЗХГ-аас ирүүлсний дагуу энэхүү судалгааг гүйцэтгэв.

1.2. Зорилго:

Сүм хийдүүдийн үйл ажиллагаанд хамрагддаг хүүхдүүдийн талаарх мэдээллийг цуглуулж дүн шинжилгээ хийх, хүүхдэд чиглэсэн сүм хийдийн үйл ажиллагааны өнөөгийн цар хүрээг тогтооход судалгааны эцсийн зорилго чиглэнэ.

Судалгааны явцад дараах зорилтуудыг дэвшүүлсэн болно. Үүнд:

- ✓ Үйл ажиллагаандаа хүүхэд хамруулж буй сүм хийдүүдийн тоог аймаг, нийслэлээр тодорхойлон гаргах;
- ✓ Шавилан суудаг болон үйл ажиллагаанд нь өдрөөр хамрагддаг хүүхдүүдийн тоог нас, хүйсийн ялгаатай байдлаар тогтоох;
- ✓ Хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдлыг үнэлэх;
- ✓ Сүм хийдээс хүүхдэд үзүүлж буй үйлчилгээг тодорхойлох;
- ✓ Сүм хийдийн үйл ажиллагаанд хамрагдаж буй хүүхдүүдийн сэтгэл ханамжийн байдлыг тодорхойлох;
- ✓ Судалгааны үр дүнгээр санал, зөвлөмж дэвшүүлэх;

ТББ, ББСБ, ХХК, эмнэлэг, худалдааны төв, сургууль, цэцэрлэг, хүүхийн зуслан, хэвлэлийн статус бүхий байгууллагыг хамруулсан байсан болно.

¹⁰ Гадаадын болон олон улсын шашны төрийн бус байгууллагуудын Монгол дахь үйл ажиллагаа, үр нөлөө" судалгаа. ХСИС.2017 он.

¹¹ Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан. ХЗДХЯ.2018 он.

БҮЛЭГ 2. АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Хамрах хүрээ:

Хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж буй 17 аймаг, 6 дүүргийн нийт 127 сүм, хийдүүдийн багш, ажилтан болон сүм хийдэд шавилан суусан 70 хүүхэд, өдрөөр ирж үйл ажиллагаанд нь тогтмол хамрагддаг 44 хүүхдийг тус тус хамруулсан.

2.2. Судалгааны аргууд

Хоёрдогч баримт бичгийн шинжилгээ болон анхдагч мэдээлэл цуглуулах тоон болон чанарын судалгааны аргуудыг хослуулан хэрэглэсэн. Үүнд:

Асуулга: Энэ аргаар сүм хийдийн баг, ажилтнаас хичнээн хүүхэд ямар хугацаагаар шавилан суудаг болон өдрөөр үйл ажиллагаанд хамрагдаг, ямар үйлчилгээ үзүүлдэг, хүүхэд хамгааллын нөхцөл байдлыг тодорхойлох мэдээллийг цуглуулж дүн шинжилгээ хийсэн.

Ганцаарчилсан ярилцлага: Ганцаарчилсан ярилцлагаар хүүхдийн ар гэрийн байдал, хүүхдийн эрхийн зөрчил болон сүм хийдээс үзүүлж буй үйл ажиллагааны сэтгэл ханамжийг тодорхойлох зэрэг илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахад ашиглав.

Баримт бичгийн шинжилгээ: Энэ чиглэлээр хийгдсэн судалгааны тайлан материалууд болон холбогдох хуулиудад дүн шинжилгээ хийсэн.

2.3. Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт

Судалгааны арга зүйг ГБХЗХГ-ын ССМТ боловсруулан, 2019 оны 6 дүгээр сарын 1-9 сарын 20 -ны хооронд аймаг, дүүргийн ГБХЗ-ын хэлтэс, газрын хүүхдийн эрхийн байцаагч, мэргэжилтнүүдтэй хамтран мэдээлэл цуглуулалтын ажлыг гүйцэтгэлээ.

Судалгааны асуулгыг шалгаж, хүлээн авч мэдээллийг компьютерт шивж оруулах, бүрдэлтийг хянах, засварлах, боловсруулах, нэгдсэн үр дүнг гарган авах ажлуудыг Сургалт, судалгаа мэдээллийн төв хийж гүйцэтгэсэн.

БҮЛЭГ 3. МОНГОЛ УЛСЫН ШАШНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

3.1. Олон улсын гэрээ болон дотоодын эрх зүйн байдал

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд шашин шүтэх эрх, эрх чөлөөг дараахь байдлаар тусгасан байдаг. Үүнд:

- “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”¹²-ын 18 дугаар зүйлд “Хүн бүр бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх эрхтэй. Энэхүү эрхэд шашин буюу шүтлэгээ өөрчлөх эрх чөлөө, бие даан болон бусадтай хамтран нийтийн өмнө болон хувийн журмаар хичээл заах, хурал мөргөл хийх, шашны хийгээд зан үйлийн ёслол үйлдэх зэргээр шашин буюу шүтлэгээ номлох эрх чөлөө багтана”;
- “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”¹³-ын 18 дугаар зүйлийн

18.2 дахь хэсэгт “Хэний ч өөрийн сонгосон шашин буюу шүтлэгтэй байх, эсхүл тийм шашин буюу шүтлэгтэй болох эрх чөлөөг хязгаарлахаар албадан шахах ёсгүй”, 18.3 дахь хэсэгт “Шашин буюу шүтлэгээ номлох эрх чөлөөг зөвхөн хуулиар тогтоосон болон нийгмийн аюулгүй байдал, хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун бусдын үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах шаардлагын үүднээс хязгаарлаж болно”, 18.4 дэх хэсэгт “Энэхүү Пактад оролцогч улс эцэг эхийн болон зохих тохиолдолд хууль ёсны асран хамгаалагчдын үр хүүхэддээ хувийн үзэл итгэлийнхээ дагуу шашны болон ёс суртахууны хүмүүжил олгох эрх чөлөөг хүндэтгэх үүрэг хүлээнэ” гэж тус тус заажээ.

Монгол Улсын Үндсэн хууль, Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль ба бусад холбогдох хууль тогтоомж болон Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд дээр дурдсан олон улсын гэрээнд заасан иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг баталгаажуулж, төр ба шашны харилцааг зохицуулсан билээ.

Энэ хүрээнд дэлгэрүүлэн авч үзвэл, Монгол Улсын Үндсэн хуулийн Есдүгээр зүйлд төр, сүм хийдийн хоорондын харилцааг тусгайлан хуулиар зохицуулахаар хуульчилж өгсний дагуу 1993 онд Улсын Их Хурлаас Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль/цаашид ТСХХтХ гэх/-ийг баталж мөрдүүлсэн. Уг хууль батлагдсанаас хойш нийт 5 удаа (1995, 1997, 2014 онд тус бүр 1 удаа, 2015 онд 2 удаа) нэмэлт, өөрчлөлт оржээ¹⁴.

¹² Монгол Улсын олон улсын гэрээ, Төрийн мэдээлэл, /тусгай дугаар/ I боть, 2004, 8 дахь тал.

¹³ Монгол Улсын олон улсын гэрээ, Төрийн мэдээлэл /тусгай дугаар/ I боть, 2004, 18 дахь тал.

¹⁴ Төр, сүм хийдийн харилцааг зохицуулах хууль тогтоомж, сүм хийд, лам санваартны үйл ажиллагааны эрх зүйн үндэс, сүм хийд байгуулах, сүм хийдийн үйл ажиллагааг зогсоох, сүм хийдийн өмч, аж ахуйн харилцааг зохицуулах, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага зэрэг асуудалтай холбоотой нэмэлт, өөрчлөлт оржээ

ТСХХТХ-ийн 1 дүгээр зүйлд “Монгол Улсын Үндсэн хуулиар зарлан тунхагласан иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хангах баталгааг тогтоож, төр, сүм хийдийн хоорондын харилцааг зохицуулахад оршино” гэж заасан. Эндээс авч үзвэл, уг хуулийн зорилт нэгдүгээрт, иргэний шашин шүтэх эрхийг баталгаажуулах, хоёрдугаарт, төр ба сүм хийдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршиж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төр болон шашны байгууллага болох сүм хийдийн хоорондын харилцааны эрх зүйн үндсийг тогтоож, “Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ” хэмээн заасан нь төр, сүм хийдийн харилцааны үндсэн зарчим болж өгсөн.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэж зааснаар хүний эрхийг хангахад баримтлах суурь зарчмыг тогтоов.

2008 оны Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт “Төр, сүм хийдийн харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгож, хүн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөгөө эдлэх эрх зүйн баталгааг Үндсэн хуульд нийцүүлэн төгөлдөржүүлэх арга хэмжээ авна” гэж тусгасан. Энэхүү зорилтын хүрээнд төр, сүм хийдийн хоорондын харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох ажил өнөөг хүртэл хангалттай хэмжээнд хэрэгжээгүй байна. Төр болон шашны үйл ажиллагаа тусдаа байх эрх зүйн нарийвчилсан зохицуулалт гараагүй тул хүүхдийг хүмүүжүүлэх, асран хамгаалах, боловсрол олгох үе болон ийм үйл ажиллагаа эрхлэн явуулж буй байгууллага дээр шашны нөлөө, оролцоо ямар байх талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй байна гэж дүгнэсэн¹⁵.

3.2. Шашны байгууллага, түүний бүртгэл

ТСХХТХ-ийн 6 дугаар зүйлд “Сүсэгтэн олны шашин-номын эрэлт хэрэгцээг хангах зорилгоор байгуулагдаж, шашны зан үйл, хурал ном, боловсролын ажлыг эрхлэн гүйцэтгэж буй албан ёсны зөвшөөрөл бүхий хийд, сүм, дацан, төв болон тэдгээрийн удирдах байгууллагыг шашны байгууллага гэнэ” хэмээн зааж, тэдгээрийг уг хуульд “сүм хийд” гэж нэрлэхээр заажээ.

Мөн хуулийн 9 дүгээр зүйлд “Сүм хийд байгуулах тухай иргэдээс гаргасан өргөдлийг дүрмийн хамт аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хянан үзэж, зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ. Олгосон зөвшөөрлийг үндэслэн сүм хийдийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн

¹⁵ Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээ тайлан, Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2008, 81 дэх тал.

төрийн захиргааны байгууллага бүртгэнэ” гэж заасан.

Иймээс ТСХХТХ-ийн хэрэгжилтийг улсын хэмжээнд хангуулах ажлын хүрээнд аймаг, нийслэлийн ИТХ-ын тэргүүлэгчид журам баталж, шинээр сүм хийд байгуулах, үйл ажиллагаа явуулахад нь зөвшөөрөл өгөх ажил 1994 оноос хэрэгжиж эхэлсэн.¹⁶

ТСХХТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.4-т заасны дагуу сүм хийд өөрийн дүрэмтэй байх бөгөөд дараахь зүйлийг дүрэмд тусгасан байна.

Үүнд:

- Сүм хийдийн нэр, хаяг;
- Шашны харьяалал, бүтэц, үйл ажиллагаагаа эхлэх үеийн бүрэлдэхүүний байдал;
- Үйл ажиллагааны хамрах хүрээ, хэлбэр;
- Шашин-номын хэрэгслийн хангамжийн байдал;
- Үйл ажиллагаа явуулах, өргөжин бэхжих хөрөнгө санхүүгийн бодит боломж, анхдагч хөрөнгийн хэмжээ;
- Хуулийн этгээд болох үндэслэл;
- Бусад зүйл.

Сүм хийд дүрэмдээ оруулсан нэмэлт, өөрчлөлтийг аймаг, нийслэлийн ИТХ-д болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухай бүр мэдэгдэх үүрэгтэй. Хэрэв сүм хийдийн дүрэм, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Монгол Улсын хууль тогтоомжид харшлах бол сүм хийд байгуулах зөвшөөрөл олгохгүй буюу олгосон зөвшөөрлийг цуцална. Энэ шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо хууль тогтоомжийн дагуу шүүхэд гаргаж болохоор хуульчилсан.

Сүм хийдийн тайланг аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс/газар нэгтгэн, улирлын мэдээг улирал бүрийн дараа сарын 21-нд, жилийн эцсийн мэдээг жил бүрийн 3 дугаар сарын 4-нд Үндэсний статистикийн хороонд ирүүлдэг. 2018 онд Үндэсний статистикийн хороонд ирүүлсэн сүм хийд, шашны байгууллагын тоо болон ажилчид, лам нар, шашны сургууль, дацанд суралцагчдын тоог үзвэл, сүүлийн 10 орчим жилийн хугацаанд сүм хийдийн тоо өссөн бол 2007-2016 оны хооронд нийт шашны сургууль, дацанд суралцагчдын тоо тогтмол буурсан боловч сүүлийн хоёр жилийн хугацаанд өссөн үзүүлэлттэй байгааг Хүснэгт 1-ээс үзнэ үү.

¹⁶ “Тунгаамал төв” ТББ-аас Увс, Өвөрхангай, Сэлэнгэ, Өмнөговь аймаг, Нийслэлийн ИТХ-аас Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр баталсан журмыг судалж, зарим газрын хэрэгжилттэй танилцахад аймаг бүрт шашны байгууллагаас тавьж байгаа хүсэлтийг өөр өөр хэлбэрээр шийдвэрлэж байсан байна. Зарим газарт ажлын хэсэг байгуулан байнгын хэлбэрээр ажиллуулж байгаа бол зарим аймагт тухай бүр нь ажлын хэсэг байгуулан ажиллуулдаг. Үйл ажиллагаа явуулах болон хугацаа сунгах зөвшөөрлийг олгохдоо орон нутагт 1-3 хүртэл жилээр харилцан адилгүй сунгадаг байх жишээтэй. <http://www.khural.mn/n/w7kon> (сүүлд үзсэн: 2017.11.10)

Хүснэгт 3.1. Үндэсний статистикийн хорооны нэгдсэн санд байршуулсан тоо баримт¹⁷, (2019 он):

Д/д	Он	Будда	Христ	Ислам	Бусад	Нийт сүм хийдийн тоо	Нийт шашны сургууль дацанд суралцагчдын тоо
1.	2007	138	89	20	2	249	2251
2.	2008	116	90	15	7	228	1820
3.	2009	113	110	5	4	232	1273
4.	2010	127	96	6	5	234	1564
5.	2011	142	161	18	6	327	1362
6.	2012	148	157	24	9	338	779
7.	2013	146	151	20	0	317	591
8.	2014	141	164	25	6	336	342
9.	2015	139	183	22	12	356	269
10.	2016	136	183	22	9	350	163
11.	2017	136	180	21	7	344	259
12.	2018	134	196	24	10	364	612

Жил бүр шинээр шашны байгууллага бүртгүүлэх үйл явц хурдацтай нэмэгдэж, нутаг дэвсгэрийн хувьд өргөн тархацтайгаар үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд бүртгэлгүй шашны байгууллагын тоо мөн өсч байна.

Манай оронд шашин шүтэх эрх чөлөө бодитой хэрэгжих болсон 1990-ээд оны эхэн үеэс шашны байгууллагууд эрчимтэй байгуулагдаж эхэлсэн бөгөөд Христийн шашин болон өөр бусад шашны урсгал гаднаас нэвтэрч иргэдийг элсүүлэх болсон. Энэ үеэс сүм хийдийн бус шашны байгууллагууд бий болж эхэлжээ.

“Тунгаамал” ТББ-ын хийсэн судалгаанаас үзэхэд¹⁸ 2016 оны байдлаар, Монгол Улсын хэмжээнд

¹⁷ <https://www.nso.mn> (сүүлд үзсэн: 2017.11.27)

¹⁸ “Тунгаамал төв” ТББ-аас 1994-2006 оны хооронд улсын бүртгэлд “төрийн бус байгууллага” гэсэн ангиллаар бүртгэгдсэн байгууллагуудын үйл ажиллагаа, бичиг баримтад шинжилгээ хийхэд нийт 35 байгууллага шашны ямар нэг урсгал чиглэлийг дэмжих, шашин дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гэсэн тооцоо гарсан байна. Монголын нөхцөлд эдгээр байгууллагууд нь эрх зүйн орчноос хамаараад ТББ-ын хэлбэрээр л үйл ажиллагаагаа явуулах боломжтой юм. Эдгээр байгууллагыг Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар зохицуулах боломжгүй тул Төрийн бус байгууллагын тухай хуулийн дагуу улсын бүртгэлд бүртгэж, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгодог

зөвшөөрөлгүй 170 сүм хийд, цуглаан үйл ажиллагаа явуулж байгаагаас орон нутагт 81, Нийслэлд 89 байна. Түүнчлэн зөвшөөрөлгүй ажиллаж байгаа бөө, удган, үзмэрч, зурхайч зэрэг хувиараа ажиллаж байгаа хүмүүсийн талаарх мэдээлэл огт байхгүй байна. Эдгээр хүмүүсийн шашны үйл ажиллагаа эрхлэх боловсрол шаардлагад нийцэж байгаа эсэх, иргэдийн шашин шүтэх эрхийг хэрхэн хангаж байгаа, иргэдээс ямар хэмжээний өргөл, барьц авч байгаа зэрэг асуудалд хяналт тавих ямар ч боломжгүй байгаа талаар дурджээ.

БҮЛЭГ 4. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН

4.1. СҮМ ХИЙДЭЭС АВСАН АСУУЛГА СУДАЛГААНЫ ҮР ДҮН

4.1.1. Сүм хийдүүдийн тоон мэдээлэл

2018 оны байдлаар Монгол Улсад 364 сүм хийд үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь 2017 онтой харьцуулахад 5.0 хувиар өссөн үзүүлэлт юм. Эдгээр сүм хийдүүдийг шашны урсгалын төрлөөр авч үзвэл 53.8 хувийг христ, 36.8 хувийг будда, 6.5 хувийг ислам, 10 хувийг бусад эзэлж байна.

Сүм хийдүүдийг бүс нутгийн хувьд харьцуулахад Улаанбаатар хотод хамгийн их буюу 193 сүм хийд байна. Энэ нь нийт сүм хийдийн 53.0 хувийг эзэлж байна. Христ болон буддын сүм хийд аймаг, дүүргүүдэд түгээмэл байгаа бол Исламын сүм хийдийн тоо Баян-Өлгий аймагт 18, Ховд аймагт 2, Увс аймаг 1, нийслэл Улаанбаатар хотод 2 байв.

Үүнээс хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг сүм хийдүүдийн тоог дор харуулав. (Зураг 3.1.)


Зураг 4.1. Үйл ажиллагаандаа хүүхэд хамруулдаг сүм хийдүүдийн газар зүйн байршил, тоогоор 2019 он (N=127)



Тайлбар: N=127-Үйл ажиллагаандаа нь хүүхэд хамруулдаг сүм хийдүүдийн тоо

Судалгаанд Улсын хэмжээнд шашны үйл ажиллагаанд хүүхэд хамруулдаг 127 сүм хийдийг хамруулснаас 73 хувь нь 92 сүм хийд орон нутагт 27 хувь буюу 35 сүм хийд нийслэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрийн 98 хувь нь зөвшөөрөлтэй ба 2 хувь нь зөвшөөрөлгүй ба эдгээрийн дийлэнх нь холбогдох материалаа бүрдүүлж өгөөд зөвшөөрөл гарахыг хүлээж байгаа байдалтай байна.

Зураг 4.2. Үйл ажиллагаанд нь хүүхэд хамрагддаг сүм хийдүүдийн шашны урсгалын төрлөөр, хувиар



Улсын дүнгээр үйл ажиллагаандаа хүүхэд хамруулдаг сүм хийдүүдийг шашны урсгалын төрлөөр нь авч үзвэл христ 62%, будда 34%, ислам 4% эзэлж байна. Газар зүйн байршлаар нь авч үзвэл мөн адил нийслэл болон орон нутгийн аль алинд нь христийн шашин давамгайлж байгаа бол Исламын сүм хийд үндэсний цөөнх казак иргэд амьдран суудаг Баян-Өлгий аймагт гол төлөв үйл ажиллагаа явуулж байв.

4.1.2. Сүм хийдийн үйл ажиллагаанд хамрагддаг хүүхдүүдийн нөхцөл байдал

Улсын хэмжээнд Будда, Христ, Исламын шашны үйл ажиллагаанд 2837 хүүхэд хамрагдаж байгаагийн 84 хувь буюу 2341 хүүхэд Улаанбаатар хотод, 14 хувь буюу 476 хүүхэд орон нутагт хамрагдаж байна. Үүнээс тогтмол шавилан суудаг 564 хүүхэд байгаа бол 2238 хүүхэд сүм хийдийн үйл ажиллагаанд тогтмол хамрагдаж байв.

Зураг 4.3. Сүм хийдийн үйл ажиллагаанд хамрагддаг хүүхдүүдийн насны бүлэг, хувиар, 2019 он (N=2750)




Нийт дүнгээс харахад сүмийн үйл ажиллагаанд бүх насны хүүхдүүд хамрагддаг бөгөөд 35 хувь нь 14-18 нас, 30 хувь нь 10-13 нас, 23 хувь нь 7-9 нас, 12 хувь нь 4-6 насныхан байв. Насны бүлгийг сүм хийдэд хамрагддаг хэлбэрээр ялгаж харвал шавилан суусан хүүхдүүдийн дийлэнх нь 14-18 насных байхад өдрөөр ирж үйл ажиллагаанд нь хамрагддаг хүүхдүүдэд 4-6 настнуудын эзлэх хувь цөөнгүй байгаа нь анхаарал татаж байна.

Зураг 4.4. Сүм хийдийн үйл ажиллагаанд хамрагддаг хүүхдүүдийн хүйсийн харьцаа, хувиар



Сүм хийдэд хамрагдах байдал нь тэдний хүйсийн онцлогоос хамаарч байгаа бөгөөд хөвгүүд охидоос 16 нэгж хувиар илүү байгаа ч хамрагдах хэлбэрээр нь ангилан харвал шавилан суусан таван хүүхэд тутмын дөрөв нь хөвгүүд байхад өдрөөр үйл ажиллагаанд нь хамрагддаг хүүхдүүдийн хувьд охид хөвгүүдээс 4 нэгж пунктээр илүү байна. Өөрөөр хэлбэл, эрэгтэй хүүхдийн сүм хийдэд шавилан суух магадлал эмэгтэй хүүхдээс 4 дахин их байна. Энэ бол жендерийн хувьд анхаарал хандуулах шаардлагатай статистик үзүүлэлт юм. Харин өдрөөр ирж үйл ажиллагаанд хамрагдах хүүхдэд охидын эзлэх хувь хөвгүүдээс 4 пунктээр их байна. Өөрөөр хэлбэл сүм хийдэд шавилан суух байдал нь тэдний хүйсийн онцлогоос хамаарч байгаа бол өдрөөр үйл ажиллагаанд нь хамрагдахад хүйсийн ялгаа статистик ач холбогдолгүй байв.

Зураг 4.5. Сүм хийдийн үйл ажиллагаанд хамрагдсан хугацаа, хувиар, 2019 он (И=2750)




Нийт хүүхдүүдийн сүм хийдийн үйл ажиллагаанд хамрагдсан хугацаа нь 56 хувь нь 4-ээс дээш жил, 28 хувь нь 1-3 жил, 26 хувь нь 1 жил хүрэхгүй хугацаанд тус тус хамрагдсан байна. Харин хамрагдах хэлбэрээр нь авч үзэхэд ялгаатай байгаа ба шавилан суусан хүүхдүүдийн дийлэнх нь 8 аас жил, өдрөөр үйл ажиллагаанд хамрагддаг хүүхдүүдийн дийлэнх нь 3 хүртэл жилийн хугацаанд үйл ажиллагаанд хамрагдсан байна.

Шигтгээ 4.1 Сүм хийдэд хамрагдах байдал

Ихэнх хүүхдүүд 7 хоногийн 5 өдөр сүм дээр байрладаг. Амралтын 2 өдөр гэрлүүгээ явдаг. Зарим тохиолдолд хүүхдүүд 7 хоногт сүмд 2-3 удаа ирдэг ба өдөрт 2-3 цагийг сүмд өнгөрүүлдэг ба нийтийн уншлагатай өдөр эцэг эхийн хамт ирж оролцдог. Дугуйланд ч бас хамрагддаг.

(Буддын сүм хийдийн багштай хийсэн ярилцлагаас)

Зураг 4.6. Сүм хийдийн үйл ажиллагаанд хамрагддаг хүүхдийн ар гэрийн байдал, хувиар, 2019 он (N=2750)




Сүм хийдийн үйл ажиллагаанд хамрагдаж буй дөрвөн хүүхэд тутмын нэг нь бүтэн болон хагас өнчин хүүхэд байгаа боловч хамрагдаж байгаа хэлбэрээр нь ялган харвал шавилан суусан хүүхдүүдийн бараг тал хувь нь бүтэн болон хагас өнчин байхад өдрөөр ирж үйл ажиллагаанд хамрагддаг хүүхдүүдийн хувьд энэ үзүүлэлт 20 буюу 2.5 дахин бага байв.

Шигтгээ 4.2 Сүм хийдэд хамрагдаж буй хүүхдүүдийн ар гэрийн байдал

Боломжийн амьдралтай айлын хүүхэд ирэх тохиолдол байдаг ч ихэнхдээ эцэг эх нь нас барсан хагас болон бүтэн өнчин, хайр халамж дутагдсан эсхүл сургууль завсардсан амьжиргааны түвшин доогуур айлын хүүхдүүд ирдэг.

(Буддын сүм хийдийн багштай хийсэн ярилцлагаас)

Зураг 4.7. Сургууль завсардсан хүүхэд, сүм хийдэд хамрагдах хэлбэрээр, хувиар, 2019 он (N=21)



Тайлбар: N=21-Сүм, хийдийн үйл ажиллагаанд хамрагддаг сургууль завсардсан хүүхдийн тоо

Сүм хийдэд шавилан сууж, шашны сургуульд суралцаж байгаа хүүхдүүдэд сүм хийд, дацангийн дэргэдэх шашны сургуулиар дамжуулж эсвэл албан бус боловсролын хөтөлбөрт хамруулах байдлаар ерөнхий боловсрол олгож байгаа хэдий ч ерөнхий боловсрол эзэмшиж чадалгүй завсардаж байгаа хэсэг ч бас байна. Сургууль завсардсан арван хүүхэд тутмын есөөс их нь буюу 95 хувь нь шавилан суусан хүүхэд байгаа бөгөөд үүнээс 90 орчим хувь нь орон нутгийн сүм хийдэд шавилан сууж байна.

Зураг 4.8. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сүм хийдэд хамрагдалтын хэлбэрээр, хувиар, 2019 он (N=16)



Тайлбар: N=16-Сүм, хийдийн үйл ажиллагаанд хамрагддаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо

Сүм хийдийн үйл ажиллагаанд хамрагддаг хөгжлийг бэрхшээлтэй дөрвөн хүүхэд тутмын гурав нь өдрөөр үйл ажиллагаанд нь хамрагддаг ба харьяаллаар нь авч үзвэл 90 гаруй хувь нь орон нутгийн хүүхдүүд байна.

4.1.3. Сүм, хийдээс хүүхдүүдэд үзүүлж буй үйлчилгээ болон хамгааллын асуудлууд

Зураг.4.8. Сүм хийдэд ирж өдрийн үйлчилгээ авах болон шавилан суухад ямар нэгэн шалгуур болзол байдаг эсэх




Таван сүм хийд тутмын нэг нь шавилан суудаг хүүхдүүддээ тодорхой хэмжээний шалгуур тавьдаг ба үүнд эцэг эхтэйгээ хамт ирэх, эрүүл мэндийн байдал-оюун ухааны сааталгүй, биендээ сорвигүй, IQ , эерэг харилцааны зан чанар, насны ангилал зэрэг шалгуур тавьдаг байна. Харин сүмийн үйл ажиллагаанд хамрагддаг хүүхдүүдийн хувьд ямар нэгэн шалгуур үзүүлэлт тавихгүй өөрийн хүсэл сонирхлоор хамрагддаг байна.

Шигтгээ 4.2 Сүм хийдэд хамрагдаж буй хүүхдүүдийн ар гэрийн байдал

Насанд хүрээгүй хүүхдийн эцэг эхийн зөвшөөрлийг бичгээр авдаг ба шашны үүднээс таван шинж эрхтэн бүтэн байх, нүүр амандаа сорвигүй байх, ухаан санааны сааталгүй, хөгжлийн бэрхшээлгүй байх, зэрэг шаардлага тавьдаг .

(Буддын сүм хийдийн багштай хийсэн ярилцлагаас)

Зураг 4.9. Үйл ажиллагаанд өдрөөр ирж хамрагддаг хүүхдүүдийн давтамж, хувиар




Судалгаанаас үзэхэд хүүхдүүдийн 80 гаруй хувь нь амралтын өдөр буюу бямба, ням гаригуудад, 17 хувь нь 7 хоногт 3-5 өдөр үйл ажиллагаанд нь хамрагддаг бол цөөн тохиолдол буюу 6 хувь нь өдөр бүр сүмд ирж үйлчилгээ авдаг байна.

Зураг 4.10. Шашны ном, библи сурахаас гадна бусад үйл ажиллагаанд хамрагдах байдал




Зураг 4.11. Ямар нэг сургалтын төлбөр, хоолны мөнгө зэрэг нэмэлт зүйл хүүхдүүдээс шаарддаг талаар



Үйл ажиллагаандаа хүүхэд хамруулдаг нийт сүм хийдийн 98.5 хувь нь төлбөргүй бол 2 сүм хийд дотуур байр нь төлбөртэй ба энэ нь Баян-Өлгий аймагт үйл ажиллагаа явуулдаг Исламын сүм байна. Амьжиргааны түвшнээс хамаарч

200-500 мянган төгсрөгний төлбөр авдаг ба сайн сурвал жилийн эцэст төлбөрийг нь буцаан олгодог байлаа.

Зураг 4.12. Хүүхдүүдэд ямар нэг хэлбэрээр урамшуулал өгдөг эсэх



Шавилан суудаг болон өдрөөр ирж хамрагддаг хүүхдүүдийн дийлэнх буюу 64 орчим хувь нь аль нэг хэлбэрийн урамшуулал олгодог, үүнээс 50 гаруй хувьд нь тэмдэглэлт баярын үеэр урамшуулал болгон бэлэг гардуулдаг,

хувь нь хичээлийн хэрэглэл өгдөг, амжилттай сурвал жилийн эцэст шагнах, хувцас эд материалын дэмжлэг өгөх зэргээр урамшуулдаг байна. Шавилан суудаг хүүхдүүдийн хувьд урам зориг өгөх зорилгоор онц суралцсан хүүхдүүдээ урамшуулах, жилийн эцэст шагнах нь олонтоо байна.

Шигтгээ 4.2 Сүм хийдэд хамрагддаг хүүхдүүдийн урамшууллын тухай

Шавилан суудаг хүүхэд

Ном уншлага даган баяссан хандивыг цуглуулж шинээр дээл хувцас хийлгэж өгдөг. Мөн Суусан цагаар нь сар бүр зээ барьдаг. Жилдээ нэг удаа шалгалт аваад хамгийн сайн байгаа хүүхдэдээ талархал мөнгөн шагнал олгодог.

(Буддын сүм хийдийн багштай хийсэн ярилцлагаас)

Өдрөөр ирж үйл ажиллагаанд нь хамрагддаг хүүхэд

Шинэ жил, хүүхдийн баяр, хичээлийн шинэ жилээр бэлэг, хүүхдүүдийн төрсөн өдрийг сар сард нь нийлүүлэн тэмдэглэж өгөх заримдаа кино үзвэр үзэх, сургалт семинарт хамруулдаг ба өвөл дулаан хувцас, намар хичээлийн хэрэгсэл бэлтгэн тараадаг. Мөн хүүхдийн хоол хөтөлбөр хэрэгжүүлдэг.

(Христийн сүмийн багштай хийсэн ярилцлагаас)

Хүснэгт 4.1. Шавилан суусан хүүхдийн эрхийн зарим нөхцөл байдал, хувиар

Шалгуур үзүүлэлт	Хувийн жин	
	Тийм	Үгүй
Шавилан суудаг болон өдрөөр ирж хамрагддаг хүүхдийн анкет	58	42
Хүүхэд хамгааллын бодлогын дүрэмтэй эсэх	41	59
Багш, ажилтан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн, илрүүлсэн тохиолдолд хуулиар хүлээлгэсэн үүргийг сургуулийн болон хүүхэд хамгааллын дүрэмд тусгасан эсэх	56	44
Үйл ажиллагаандаа хүүхэд хамгааллын үнэлгээ хийлгэсэн эсэх	40	60
ЕБС-ийн хичээл ороход мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан уу?	25	75
Ном сурах бичиг бүрэн хангагдсан эсэх	31	69
Хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагч нар багштай байнгын харилцаа холбоотой байж чаддаг уу?	75	25
Хүүхэд өвдсөн тохиолдолд эцэг эх, асран хамгаалагчдад нь мэдэгддэг үү	65	35
Эмчтэй эсэх	11	89

Хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг сүм хийдүүдийн 41 хувь нь хүүхэд хамгааллын бодлогын дүрэмтэй бөгөөд тэдний тал орчим хувьд нь багш, ажилтан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн, илрүүлсэн тохиолдолд хуулиар хүлээлгэсэн үүргийг нь хүүхэд хамгааллын дүрэмд тусгасан байна. Мөн 53 хувь нь хүүхдийн анкетын мэдээлэл байгаа хэдий ч хүүхдийн мэдээллийг бүрэн гүйцэт бөглөөгүй, мөн эцэг эхтэй байгуулсан гэрээ маш хангалтгүй байгаа нь ажиглагдлаа.

Шавилан суудаг хүүхдүүдийн хувьд ЕБС-ийн зарим хичээлийг үздэг боловч тэдний 25 орчим хувь нь мэргэжлийн багш болон ном сурах бичгээр бүрэн хангагдсан байв. Түүнчлэн хүүхэд шавилан суудаг 10 хийд тутмын нэг нь дотуур байрандаа гэрээт эмч ажиллуулж байна.

4.2. ШАВИЛСАН БОЛОН ӨДРӨӨР ИРЖ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДДАГ ХҮҮХДҮҮДЭЭС АВСАН ГАНЦААРЧИЛСАН ЯРИЛЦЛАГЫН ҮР ДҮН

4.2.1. Судалгаанд хамрагдагсдын ерөнхий шинж

Үйл ажиллагаандаа хүүхэд хамруулдаг 17 аймаг, 6 дүүргийн сүм хийдэд шавилан суудаг 70 хүүхэд, өдрөөр үйл ажиллагаанд нь хамрагддаг 44 хүүхэд нийт 8-18 насны 114 хүүхдийг ганцаарчилсан ярилцлагад хамруулсан.

Чанарын судалгааны үр дүнгээр шавилан суусан хүүхдийн хагас болон бүтэн өнчин байх магадлал өдрөөр ирж үйл ажиллагаанд хамрагддаг хүүхдүүдтэй харьцуулахад 3 дахин их байна. Уг статистик сүм хийдээс авсан тоон судалгаагаар мөн батлагдсан болно. Түүнчлэн шавилан суусан гурван хүүхэд тутмын нэгнийх нь гэр бүл малчин байгаа бол, өдрөө үйл ажиллагаанд нь хамрагддаг хүүхдүүдийн эцэг эхийн ажил эрхлэлтэнд төрөл бүрийн салбарт ажилладаг байна. Харин эцэг эхийнх нь аль нэг нь ажилгүй байх тохиолдол өдрөөр хамрагддаг хүүхдүүд шавилан суусан хүүхдийнхээс 2.5 дахин өндөр байлаа.

Мөн шавилан суудаг хүүхдүүдийн дийлэнх нь айлын дунд хүүхэд зонхилж байгаа ба дунд хүүхэд байх магадлал ууган хүүхдээс 2 дахин, отгон хүүхдээс 5 дахин их байна. Харин өдрөөр үйл ажиллагаанд нь ирж хамрагддаг хүүхдүүдийн хувьд дээрх үзүүлэлтээр статистикийн ач холбогдолтой ялгаа ажиглагдахгүй байна.

4.2.2. Сүм хийдийн хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаанд татагдаж буй шалтгаан

Шавилан суусан болон өдрөөр хамрагдаж буй хүүхдүүд ерөнхийдөө өөрийн итгэл үнэмшлээр лам болохоор шийдсэн гэж үзэж багаа бол цөөн тохиолдолд гэр бүлийнхний хүсэлт, шийдвэрээр хамрагдах болсон байна. Мөн зарим хүүхдүүд англи хэл, математик, гитар, теннис, хөгжөөнт тоглоом зэрэг өөрийгөө хөгжүүлэх зорилгоор хамрагдаж байгаад шаны итгэл үнэмшилтэй болсон байна. Нөгөө талаас тэдний дийлэнх нь эмзэг бүлгийн, амьжиргааны түвшин доогуур айлын хүүхдүүд ирдэг гэдэг нь судалгаагаар нотлогдсон бөгөөд ихэвчлэн хувцас хунараар хангах, аливаа баярын үеэр тэдэнд бэлэг өгдөг нь хүүхдүүдэд таалагддаг байна.. Цөөнгүй тохиолдолд зарим буддын сүм хийдийн зүгээс хүүхдүүдэд сар бүр 50-360 мянган төгрөгийн урамшуулал болгон өгдөг байна.

“Өвөө минь лам байсан ба намайг сайн лам болоорой гээд судраа өвлүүлсэн тул өвөөгийн захиасаар ирсэн. 23 хоног хуралд таслалгүй оролцохоор сард 192000-320000₮-ийн цалин авдаг. Хоолыг хийд хариуцдаг, хувцасаа өөрсдөө авдаг”

- Буддын сүм хийдэд шавилан суусан хүүхдийн ярилцлагаас

“Манай аав хийдийн манаач хийдэг байсан болохоор тус хийдийн лам багш маань намайг хараад лам болохоор хүүхэд байна гээд лам болсон. Би өөрөө ч бас дуртай байсан. Овоо уулын тахилга, ном хурах үед өгсөн гарын мөнгийг цуглааж байгаад буцаад шинэ дээл хувцас хийж өгөх, бөхийн барилдаанд сайн барилдах, мөн баярын үеэр бэлэг өгдөг нь таалагддаг”

- Буддын сүм хийдэд шавилан суусан хүүхдийн ярилцлагаас

“Эмээгийн зөвлөснөөр, Эмээ багшилдаг байж байгаад тэтгэвэртээ гараад сүмд явдаг болсон, одоо эмээ бас 1 дүүтэйгээ хамт явдаг. Манай гэрийхэн сүм явахыг дэмждэг. Дуу бүжиг, тоглоом, англи хэл, монгол хэлний хичээл заадаг, бас бэлэг өгдөг.”

-Христийн сүмд хамрагддаг хүүхдийн ярилцлагаас

4.2.3. СҮМ ХИЙДИЙН ХҮҮХДИЙН ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАНД ХАМРАГДДАГ ХҮҮХДҮҮДИЙН ЭРХ, ХАМГААЛЛЫН АСУУДЛУУД

4.2.3.1. Сүм хийдэд амьдарч буй хүүхдүүдийн амьдрах орчин

Зарим томоохон сүм хийдэд шавилан сууж буй хүүхдүүдийн хувьд дотуур байртай бөгөөд өөрийн гэсэн өрөө тасалгаатай байна. Ах хүүхдийг дүү нартай нь хамт, насны ангиллаар, нэг гэрийн хүүхдүүд гэх мэт ангиллаар багш нар нь хувиарладаг байна. Шавилан сууж буй хүүхдүүд амьдардаг орчин нөхцөлөө боломжийн гэж үнэлж буй боловч бодит байдал дээр тэдний сууж байгаа амьдардаг байр нь өнөөгийн шаардлагад нийцээгүй, нэг өрөөнд 4-7 хүүхэд хамт амьдардаг ба зарим газар 15 ам.метрийн хэмжээтэй өрөөнд 10 хүүхдийг нэг дор байрлуулсан, түүнээс ч дор нөхцөлд байлгадаг нь ажиглагдсан. Дээрээс нь, эдгээр байгууллага хүүхдүүдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх орчныг бүрдүүлж өгөөгүй, биеийн тамирын заал, урлагийн зэрэг соёл хүмүүжлийн ажилд зориулсан анги танхим маш цөөн байна.

Хийдээс шавилан суралцаж байгаа хүүхдүүдэд дотуур байр барьж өгсөн, өрөөндөө 8 уулаа амьдардаг дотроо угаалтуур болон нойлтэй, өрөөгөө өөрсдөө цэвэрлэдэг.

- Буддын сүм хийдэд шавилан суусан хүүхдийн ярилцлагаас

Ахындаа амьдардаг. Хурал ихтэй үед хийдийн 2 давхарт байранд байдаг бөгөөд ор хөнжлийн даавуугаа өөрөө авч ирсэн, зарим хүүхдэд эндээс нь өгдөг. Байрны цэвэрлэгээг үйлчлэгч хийдэг

- Буддын сүм хийдэд шавилан суусан хүүхдийн ярилцлагаас

4.2.3.2. Сүм хийдийн дотоод дүрэм журам

Дуганд гүйх, дуулах, хараал хэлэхгүй, амьтны амь таслахгүй, хурал дундуур босож явахгүй, хоорондоо ярихгүй, ах нарын өөдөөс сөргөлдөхгүй, хурал, хичээл таслахгүй гээд зөндөө юм байдаг

-Буддын сүм хийдэд шавилан суусан хүүхдийн ярилцлагаас

Цуглаанаа таслахгүй оролцох ба энэ үер утас оролдохгүй, чимээ шуугиан гаргаж болохгүй, хараалын үг хэрэглэхгүй

Христийн сүм хийдэд шавилан суусан хүүхдийн ярилцлагаас

Хатуу дүрэм байхгүй. Бид хичээл хийх явцдаа бусдад саад болохгүйгээр сайн ойлгох, хичээгээрэй гэдэг, хог хаяж болохгүй, байгалиа хамгаалаарай гэдэг.

(Христийн сүм хийдэд шавилан суусан хүүхдийн ярилцлагаас)

Бохь зажилж болохгүй, хөөцөлдөж тоглож болохгүй, бусдыг хүндлэх, богино шорт өмсөж болохгүй

-(Исламын сүм хийдэд шавилан суусан хүүхдийн ярилцлагаас)

4.2.3.3. Хүүхэд- эцэг эхчүүдийн харилцаа холбоо

Буддын шашны сургуульд сурч буй хүүхдүүд хүссэн үедээ эцэг эхтэйгээ утсаар ярих боломжтой тухай хүүхдүүд ярьж байсан. Хүүхдүүд ар гэрийнхэнтэйгээ 7 хоногт 3-4 удаа утсаар ярьдаг ба ойрхон гэртэй хүүхдүүд 7 хоногийн амралтын өдрүүдэд гэртээ хариад ирдэг байна. Хол гэртэй буюу өөр аймаг, хотоос ирж шавилан сууж буй хүүхдүүдийн эцэг эхчүүд хагас жилд 1-2 удаа эргэж ирдэг харин ойрхон гэртээ (тухьян аймаг орон нутагт ар гэр нь байдаг) хүүхдүүдийн эцэг эхчүүд сард бүр ирж уулздаг байна. Харин Христийн сүмийн үйл ажиллагаанд өдрөөр ирж хамрагддаг хүүхдүүдийн эцэг эх, гэр бүлийн гишүүдтэй нь холбоотой байдаг ба хүүхдүүд эцэг эх, гэр бүлийн аль нэг гишүүнтэйгээ хамт сүмд ирэх нь түгээмэл байна.

Зарим тохиолдолд хүүхдүүд ирэхгүй байх үед нь хүүхдийн гэрээр нь очиж эцэг эхтэй нь уулздаг байна.

Манайх энд төв дээр байдаг болохоор хоёр 7 хоноод аав ээж эргэж ирдэг, би амралтын өдрөөр багшаасаа зөвшөөрөл аваад ихэвчлэн гэр лүүгээ явдаг. Өөрийнхөө гар утсаар хүссэн үедээ гэрийнхэнтэйгээ өдөр бүр утсаар ярьдаг.

-Буддын сүм хийдэд шавилан суусан хүүхдийн ярилцлагаас

Эмээгийн зөвлөснөөр, Эмээ багшилдаг байж байгаад тэтгэвэртээ гараад сүмд явдаг болсон, одоо эмээ бас 1 дүүтэйгээ хамт явдаг. Манай гэрийнхэн сүмд явахыг дэмждэг ба зарим үед ээжтэй хамт ирдэг.

(Христийн сүмийн үйл ажиллагаанд хамрагддаг хүүхдийн ярилцлагаас)

4.2.3.4. Сүмийн үйл ажиллагаанд хамрагдаж буй хүүхдүүдийн ЕБС-ийн хамрагдалт

Чанарын судалгаанд хамрагдсан шавилан суудаг 70 хүүхдийн 25 нь сургууль завсардсан ба үүнээс 9 нь насан туршийн боловсролын төвийн дүйцүүлэх хөтөлбөрт хамрагдсан байна. Гэтэл сүм хийдийн багш, ажилтнуудаас авсан тоон судалгаагаар 564 шавилан суудаг хүүхдээс 26 нь сургууль завсардсан гэсэн дүн гарсан бөгөөд үүнээс дүгнэхэд шашны сургуульд суралцагч сургууль завсардсан хүүхдийн тоо бодитой эсэх нь эргэлзээтэй байна. Гэхдээ тухайн сүм хийдээс хүүхдүүдэд ерөнхий эрдмийн багш нараар албан бус сургалт явуулдаг ч энэ нь төдийлөн үр дүнтэй биш байна.

Сайншанд сумын ЕБ-ын 1-р сургуульд 5 ани хүртлээ сураад лам болсон үеэс хичлээлийн цаг давхцаад сургуулиасаа гарсан.

-Буддын сүм хийдэд шавилан суусан хүүхдийн ярилцлагаас

“ЕБС-ийн 5-р ангид суралцаж байгаад орон нутаг руу шилжихээр болоод сургуулийг гарсан, тэгээд шилжихээ болиод эндээ үлдсэн. Тэрнээс хойш сургуульд яваагүй” тоо, түвд үсэг, цээж бичиг, хуулан бичиг, зохион бичлэг хийдэг. Хааяа НТБТ-өөс багш ирж монгол хэл, математикийн хичээл заадаг.

-Буддын сүм хийдэд шавилан суусан хүүхдийн ярилцлага

4.2.3.5. Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагддаг байдал

Сүм хийдүүдээс авсан судалгаагаар хүүхэд шавилан суудаг 10 хийд тутмын нэг нь эмчтэй байлаа. Эмчгүй сүм хийдүүд хүүхэд өвдсөн тохиолдолд харьяалах сум, дүүрэг, ӨЭМТ-өөс эрүүл мэндийн үйлчилгээг авдаг байна.

Бараг өвддөггүй, хааяа өвдсөн үед багшидаа хэлээд сумын эмнэлэгт очиж үзүүлдэг.

-Буддын сүм хийдэд шавилан суусан хүүхдийн ярилцлагаас

Манай дотуур байр эмчтэй эхлээд дотуур байрныхаа багшид хандаад эмчид үзүүлдэг. хавар намартаа сумын төвөөс эмч ирж үзлэг хийдэг.

-Буддын сүм хийдэд шавилан суусан хүүхдийн ярилцлагаас

4.2.3.6. Хоол, ундны чанарын үнэлгээ

Хоол ундны чанарыг шавилан суудаг хүүхдүүдийн 95 хувь нь хангалттай сайн амт чанартай байсан ба ихэнх нь өдрийн 3 хоолонд ордог ба зарим үед өөрсдөө эсхүл үйлчлэгч хийх тохиолдол ч байна.

өглөөд цай боорцог, өдөр нэг хоёрдугаар хоол, орой хоёрдугаар хоолтой амт сайн, сургуулийн тогооч хоолоо хийдэг

-Буддын сүм хийдэд шавилан суусан хүүхдийн ярилцлагаас

өглөөд цай боорцог, өдөр, оройн хоол, зарим үед өөрсдөө, зарим үед үйлчлэгч хоолоо хийдэг

-Буддын сүм хийдэд шавилан суусан хүүхдийн ярилцлагаас


4.2.3.7. Хүүхэд сэтгэл санааны хувьд таагүй байх, ганцаардах, гэрээ санах үед багш нарын зүгээс авдаг арга хэмжээ

Христийн сүмд өдрөөр ирж үйл ажиллагаанд нь хамрагддаг хүүхдүүдийн эцэг эх гэр бүлийн гишүүдтэй нь хамт ярилцаж, хамтдаа залбирал үйлддэг бол шавилан суусан хүүхдүүдийн хувьд гол төлөв гэр лүү нь чөлөө олгож явуулах, гэр бүлийнхэнтэй нь утсаар яриулах, ганцаарчлан сэтгэл зүйн зөвлөгөө өгөх зэрэг арга хэмжээг авдаг байв.

- *Эцэг, эх, асран хамгаалагчид хандана. Багш нарын зүгээс зөвлөгөө өгнө*
- *Ганцаарчлан ярилцан зөвлөгөө өгдөг мөн ар гэрийнхэнтэй нь утсаар яриулдаг.*

- Гэрт нь байлгах хэд хоногийн чөлөө олгодог эсхүл амралтын өдрүүдэд гэрт явуулдаг, янз бүрийн дугуйлан зохион байгуулдаг, сэтгэл санааны дэмжлэг үзүүлдэг.
- Сүмийн пастер хүүхдүүдтэй ярилцлага зохион байгуулж, хамдаа залбирч өгдөг. .
- Эцэг эхтэйгээ хамт цуглаанд ирдэг тэдэнтэй хамт ярилцдаг
- Багш нар тайвшруулж ярилцаж аргаддаг
- Хэрэв хүүхэд таагүй байгааг мэдэх тохиолдолд ярилцах ба эцэг эхийг хүүхэдтэйгээ ярилцах, анхаарал тавихад зөвлөнө.

Зураг 4.13. Сүм хийдэд сахилга шийтгэл болон бие биенийгээ ялгаварлан гадуурхах насны ялгаа байдаг эсэх



Тайлбар: N=114-Сүм, хийдийн шавилсан болон өдрөөр үйл ажиллагаанд нь оролцдог ярилцлагад хамрагдсан хүүхдийн тоо

Шавилан суусан болон өдрөөр үйл ажиллагаанд хамрагддаг хүүхдүүдийн хувьд багш ажилтны харилцаа эерэг, хэвийн гэж үзэж байгаа хэдий ч шавилан суудаг гурван хүүхэд тутмын нэг нь сахилга шийтгэлд хүртэж байсан байв. Тухайлбал: Мөргүүлэх, сур, бүсээр шавхуурдах, цэвэрлэгээ хийлгэх, хоол хийлгэх, зодох, эрхиддэг буюу эрхээр ороолгох, гар өргүүлэх гэх мэт. Энэ нь хүүхдүүдийн өөрсдийн эрх, хамгааллын талаарх мэдлэг мэдээлэл дутмаг байгааг илтгэж байна. Түүнчлэн сүм хийдүүдэд ялгаварлан гадуурхах байдал насны ялгаа байхгүй байгаа нь ажиглагдлаа.

Ялгаварлан гадуурхах насны ялгаа гарах зүйл байдаггүй, манай газар чинь бурхан номын газар шүү дээ. Насаар дүү боловч хийдэд хэн түрүүлж ирээд сахил хүртсэн бол тэр хүүхдийг ах гэж хүндлэх зиндаа гэж л байдаг. Харин сахилгын шийтгэл байдаг ба бид нар хоорондоо муудалцах тохиолдолд 108 мөргөх, номоо цээжлэхгүй бол гараа өргүүлж зогсоох, гаран дээрээ эрхиэр ороолгох, хацар дээр алгадуулдаг. Бас гэсгүйгийн бэрээгээр нуруун дээрээ цохиулдаг.

-Буддын сүм хийдэд шавилан суусан хүүхдийн ярилцлагаас

Сүмд ялгаварлан гадуурхах, дээрэлхэх асуудал байдаггүй, бусадтай эелдэг зөөлөн харилцарыг сүмийн багш нар заадаг учраас бие биедээ хүндэтгэлтэй харьцдаг.

-Христийн сүмийн үйл ажиллагаанд хамрагддаг хүүхдийн ярилцлагаас

4.2.4. СҮМ ХИЙДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР НӨЛӨӨ, СЭТГЭЛ ХАНАМЖИЙН БАЙДАЛ

4.2.4.1. Сүм хийдийн үйл ажиллагаанд хамрагдсанаар гарсан үр дүн эерэг өөрчлөлтийн байдал

Сүм хийдийн хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаанд хамрагдсанаар эерэг өөрчлөлт үр нөлөөтэй гэж үзсэн. Тухайлбал: өөрийгөө нээж хөгжүүлэх, өөрийгөө зөв илэрхийлэх, хүнтэй зөв боловсон харьцах, хүмүүжил, төлөвшилд эерэг нөлөө үзүүлэх, архи тамхи хэрэглэхгүй байх, ёс суртахууны боловсролд суралцах зэрэг эерэг өөрчлөлтүүд гарсан гэжээ.

Сургууль дээр дээр заадаггүй сонирхолтой сургалт ордог. Англи хэл сурч байгаа нь давуу тал болдог.

-Буддын сүм хийдэд шавилан суусан хүүхдийн ярилцлагаас

Аливаа хорт зуршил архи тамхинаас хол байлгаж, хүмүүжил төлөвшилд эерэг нөлөө үзүүлдэг, мөн залбирал хийснээр худлаа яриж хууран мэхлэхээс ангид байж бусдыг уучилж сурдаг .

-Буддын сүм хийдэд шавилан суусан хүүхдийн ярилцлагаас

4.2.4.2. Цаашдын зорилго

Шавилан суудаг хүүхдүүдийн хувьд цаашдын зорилго нь дийлэнх нь хийдийнхээ хамба лам болж бусдад туслах гэж хариулсан ба цөөнгүй тохиолдолд анагаах ухаанд шамдан суралцаж эмч болох хүсэл сонирхолтой байна. Харин сүмийн үйл ажиллагаанд өдрөөр ирж хамрагддаг хүүхдүүд хичээлдээ шамдан суралцаж , эрдэм номтой хүн болж эцэг эхийнхээ ачийг хариулах гэжээ. Үүнээс үзвэл буддын хийдэд шавилан суудаг хүүхдүүд цаашдын мэргэжлээ сонгосон зорилго нь тодорхой байгаа бол христийн сүмийн үйл ажиллагаанд хамрагддаг хүүхдүүдийн хувьд цаашдын зорилго нь ерөнхий байгаа нь ажиглагдлаа.

Энэтхэгт очиж ном сураад, олон түмэнд тустай хийдийнхээ хамба лам болохыг мөрөөддөг мөрөөдөлдөө хүрэхийн төлөө хичээнэ

(Буддын сүм хийдэд шавилан суусан хүүхдийн ярилцлагаас)

Цаашдаа уламжлалт анагаах ухаанаар суралцаж бариа засал хийдэг эмч болохыг хүсдэг.

(Буддын сүм хийдэд шавилан суусан хүүхдийн ярилцлагаас)

Эрдэм номоо сайн сурч эцэг эхийнхээ ачиг хариулж сайн хүн болох

(Христийн сүмийн үйл ажиллагаанд хамрагддаг хүүхдийн ярилцлагаас)

ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

Судалгааны Будда, Христ, Исламын 127 шашны байгууллагын үйл ажиллагаанд 2837 хүүхэд хамрагдаж байгаагийн 84 хувь буюу 2341 хүүхэд Улаанбаатар хотод, 14 хувь буюу 476 хүүхэд орон нутагт хамрагдаж байна. Үүнээс тогтмол шавилан суудаг 564 хүүхэд байгаа бол 2238 хүүхэд сүм хийдийн үйл ажиллагаанд тогтмол хамрагдаж байна. Өдрөөр шашны үйл ажиллагаанд тогтмол хамрагддаг хүүхдийн тоо шашны сургуульд суралцагч хүүхдээс даруй хэд дахин их байгаа нь цаашид анхаарах тулгамдсан асуудлын нэг юм.

Сүм хийдийн хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаанд бүх насныхан хамрагдаж буй боловч шавилан суусан хүүхдийн 3 хувь, өдрөөр ирж тогтмол үйл ажиллагаанд хамрагддаг хүүхдүүдийн 14 хувийг тус тус 0-4 хүртэлх насны хүүхдүүд эзэлж байна. Хэдийгээр хүүхдийн шашин шүтэх эрх нь хүүхдийн эрхийн конвенцийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн ч гэлээ хүүхэд ёс суртахууны хувьд зөв шийдвэр гаргах нас, сэтгэл зүйн хөгжилтэй холбоотойгоор насанд хүрээгүй хүүхдийг шашны үйл ажиллагаанд оролцуулах, шашны боловсрол олгох асуудлыг хуулиар нарийвчлан зохицуулах шаардлагатай байна. Судалгаанд хамрагдсан эдгээр шашны байгууллагын тал орчим хувь нь товч мэдээлэл төдий анкет бөглөснөөс цаашгүй байгаагаас харахад сүм хийдүүд суралцаж байгаа хүүхдийнхээ талаар дэлгэрэнгүй бүртгэл судалгаа хийдэггүй нь тодорхой байгаа тул цаашид сүм хийдэд шавилан сууж байгаа болон үйл ажиллагаанд хамрагддаг хүүхдүүдийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, үүнд хяналт тавьдаг тогтолцоог бий болгох асуудал тулгарч байна.

Ислам, христийн шашны байгууллагууд нь өөрийн байрандаа хүүхэд шавилан сургах хэлбэрийг ашиглахаас илүүтэй бямба, ням гарагт хурал, цуглаан, уншлага, ярилцлага зэрэг сүсэгтэн олонд зориулсан арга хэмжээ, мөн шашны сургаал номлолоо сурталчилах, ухуулан таниулах үйл ажиллагааг явуулдаг. Гэхдээ зарим шашны урсгал, чиглэлээс хамааран 18 насанд хүрсэн бол өөрийн гэрээс хол, сүм хийдэд сайн дурын, хүмүүнлэгийн шинжтэйгээр ажиллаж, амьдрах боломжтой бөгөөд түүний хичээл зүтгэлийг үнэлж, гадаад улсад байрлах шашны сургуульд суралцуулах зэрэг дэмжлэг үзүүлдэг байна. Буддын шашны байгууллагуудын тухайд хүүхдүүд гэрээсээ өглөө эрт хурал хурах цагт хийдэд ирэх буюу эсвэл ажлын өдрөөр хийддээ байрлах, амралтын өдрүүдэд гэртээ харих, мөн тухайн хийдийн дотуур байр, насанд хүрсэн лам нарын байранд хамт амьдрах зэргээр шавилан сууж байна. Шавилан сууж буй хүүхдүүд амьдарч буй орчноо боломжийн гэж үзэж байгаа хэдий ч бодит байдал нь өнөөгийн шаардлагад нийцээгүй, мөн эдгээр байгууллага хүүхдүүдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх орчныг бүрдүүлж өгөөгүй, биеийн тамирын заал, урлагийн зэрэг соёл хүмүүжлийн ажилд зориулсан анги танхим маш цөөн байна.

Сүм, хийдүүд хүүхэдтэй ажиллахдаа хүүхдийн эрхийн байгууллагаас хүүхдийн эрх, хамгааллын асуудлаар сургалт арга зүй авах, хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай

байгаа бөгөөд хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар нэгдсэн журам зохицуулалт хангалтгүйн зэрэгцээ насанд хүрэгчдэд зориулан гаргасан дотоод журмаа хүүхдүүдийг дагаж мөрдөхийг шаарддаг үзэгдэл нийтлэг байлаа. Түүнчлэн шавилан суудаг хүүхдүүд хүмүүжлийн эерэг арга, хандлагын талаар мэдлэг дутмаг байдаг нь судалгаанаас ажиглагдлаа. Тэд багш ажилтнуудын харилцааг нийтээрээ эерэг гэж хариулсан боловч сүм хийдэд аливаа шийтгэл байдаг эсэхийг тодруулахад буддын шашны хийдэд суралцаж байгаа хүүхдүүдтэй зүй бус харьцаж шийтгэдэг нь судалгаагаар тогтоогдов. Лам багш өөрсдийн хийж гүйцэтгэх үүрэгт ажилдаа суралцаж байгаа хүүхдүүдийг сур, бүсээр шавхуурдах, эрхиддэг буюу эрхээр ороолгодог, гар өргүүлэх, хацар дээр алгадах, гэсгүйгийн бэрээгээр нуруун дээрээ цохиулах зэрэг байдал гаргадаг гэж үзсэн байв. буддын зарим сүм хийдүүд хүүхдэд харилцааны таатай орчныг бүрдүүлээгүй гэж дүгнэж болохоор байна. Иймд эцэг эхийнхээ хараа хяналтанд амьдарч чадахгүй байгаа сүм хийдэд шавилан суудаг хүүхдүүдтэй ажилладаг хүмүүст чиглэсэн хүүхдийн эрхийн сургалт, ойлголт нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах, гомдол мэдээллээ өгөх үр дүнтэй арга хэрэгсэл, хүүхэд хамгааллын тогтолцоог хүртээмжтэй болгох замаар эдгээр хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авах шаардлагатай байна.



Сүм хийдэд шавилан суугаа хүүхдийн боловсрол эзэмших эрхийн асуудал төрийн холбогдох байгууллагын анхаарлын гадна үлдсэн хийгээд шашны байгууллага зөвхөн шашны ном заахыг урьтал болгодог шалтгаалан эдгээр багачуул ерөнхий боловсролын мэдлэгийг жирийн хүүхдүүдийн адил эзэмшиж чадахгүй бөгөөд эдгээр шашны сургуульд суралцагч сургууль завсардсан хүүхдүүдийн тоо бодитой биш байгаа нь судалгаанаас ажиглагдлаа. Учир нь, сүм хийдийн дэргэдэх сургууль БСШУЯ-нд харьяалалгүй ба тус сургуулиудыг БСШУЯ зөвшөөрдөггүй байна. Гэсэн хэдий ч шавилан суудаг хүүхдүүдэд зарим сүм хийд ЕБС-ийн цөөн тооны хичээл ордог боловч уг сургалт нь нэр төдий байна. Иймд манай улсын Боловсролын тухай хуулийн хүүхэд бүрт ерөнхий боловсролыг тэгш олгох, ТСХХтХ болон ХЭтХ-ийн хүүхэд шашин шүтэх эс шүтэх гэсэн заалтууд нь харшилж байна гэж дүгнэж болохоор байна. Иймээс сүм хийдэд шавилан суугаад суурь боловсрол давхар эзэмших боломжгүй нь нэгэнт тодорхой байгаа учраас шашны сургалттай ерөнхий боловсролын сургуулийг үндэсний хэмжээнд бүсчлэн байгуулах эсхүл суурь боловсрол эзэмшсэний дараа насанд хүрээгүй хүүхдийг шашны үйл ажиллагаанд оролцуулах, шашны боловсрол олгох асуудлыг хуулиар нарийвчлан зохицуулах шаардлагатай байгааг дахин сануулах нь зүйтэй.

Хүүхдүүд ихэвчлэн өөрсдийн хүсэл сонирхол, итгэл үнэмшлээр хамрагдсан гэж байгаа боловч нөгөө талаар сүм хийдээс өгдөг материаллаг тусламжинд нь татагдаж хандаж сүм хийдэд ирдэг ч аажмаар шашны итгэл үнэмшилтэй болдог нь ажиглагдлаа. Зарим хүүхдүүдийн хувьд сүм чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, бусад хичээлийн давтлага авах, хөгжим дуу

бүжгийн сургалт, англи хэлний сургалтанд хамрагдах зорилготой хийдэд ирэх болсон нь хүүхэд залуучуудад гадаад хэл, компьютер болон бусад сургалтын нэрийн дор шашны ном номлож байгаа нь бусдын өөрийн итгэл үнэмшлээр аливаа шашин шүтэх эрхийг зөрчиж буй хэлбэр гэж үзэж болохоор байна. Анхаарууштай нь шавилан суусан хоёр хүүхэд тутмын нэг, өдрөөр ирж хамрагддаг таван хүүхэд тутмын нэг нь тус тус хагас болон бүтэн өнчин байгааг чанарын болон тоон судалгаагаар нотлогдсон бөгөөд гадаадын хөрөнгө мөнгөтэй шашны байгууллагууд ядуурал ихтэй гэр хороололд олноор байгуулагдаж, шашны үйл ажиллагаа, сурталчилгааг идэвхитэй явуулж, ядуу орлогогүй иргэдэд гурил, будаа хоол, хуучин хувцас зэргийг тарааж насанд хүрээгүй хүүхдийг шашны үйл ажиллагаанд олноор нь татан оролцуулах элсүүлэх, ТББ болон хуулийн этгээдийн бусад хэлбэрээр халхавчлан хяналтгүйгээр шашны үйл ажиллагаа явуулах зэрэг байдал нь нэгэнт илэрхий байгаа тул сүм хийд болон шашны байгууллага /ТББ/ хоёрын ялгааг хуулинд тусгайлан зааж оруулж өгөх шаардлагатай байна.

Сүм хийдийг байгуулах зөвшөөрөл олгох эсэхийг Аймаг, нийслэлийн ИТХ-аас шийдвэрлэдэг боловч хуульд зөвшөөрөл олгоход харгалзах нөхцөл, бүртгэхээс татгалзах үндэслэлийг тусгайлан заагаагүйгээс ямар шалгуур тогтоох нь тухайн орон нутгийн ИТХ-ын эрх хэмжээний асуудал болсон байна. Ийнхүү хуульд зохицуулалтгүй орхисон хэсгийг ИТХ-аас журам баталж нөхөн зохицуулах оролдлого хийж байгаа нь зүйтэй мэт боловч шалгуурыг орон нутаг бүр өөр өөрөөр тогтоох, тухайн үеийн ИТХ-ын гишүүдийн ойлголт, хандлагаас хамаарч шалгуурыг өөрчлөх эрсдэлтэй байдал нь шашны асуудлаар Монгол Улсын баримтлах нэгдмэл бодлогыг гажуудуулж, хууль тэгш үйлчлэх, нэг мөр хэрэгжих, тогтвортой байх зарчмыг алдагдуулж хяналт, бүртгэлийг сулруулж байна. Иймд шашны байгууллагыг шинээр байгуулах, зөвшөөрөл авах, улсын бүртгэлд бүртгэхэд тавих нөхцөл, шаардлагыг шинэчлэн тогтоох, бүртгэлийн байгууллагаас шашны байгууллагыг бүртгэхээс татгалзах үндэслэлийг мөн хуулиар нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна.

ЗУРАГ 1: ХРИСТИЙН СҮМ



**ЗУРАГ 2: ГАНДАНТЭГЧИНЛЭН ХИЙДИЙН ХАРЪЯА ГУНГАА ЧОЙЛОН
ЖҮ ДАЦАН, ИДГАА ДАЦАН-(будда)**

